3.1. Суралцагчийг дэвшилтийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах

3. “ДЭВШИЛТ” үйл ажиллагааны мэдээллийг удирдах зааварчилгаа

Энэ бүлэгт цэцэрлэгийн суралцагчдыг хичээлийн жилийн төгсгөлд анги дэвшүүлэх болон тухайн ангид нь давтан суралцуулах үйлдлийн талаарх ойлголтын зааварчилгааг өгнө.

Энэ дэд бүлэг нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

Хэсэг 1: Суралцагчийг дэвшилтийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах

Хэсэг 2: Дэвших үйлдэл хийхэд анхаарах зүйлс

3.1. Суралцагчийг дэвшилтийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах

Энэ үйлдлийг бүлгийн нийт суралцагчдаас дэвших үйлдэл хийх суралцагчийг сонгож, бүртгэхэд ашиглана.

- Дэвшилтийн бүртгэл хийхээс өмнө дараах ажлууд системд хийгдсэн байх шаардлагатай.

1. Суралцагч идэвхтэй төлөвтэй, батлагдсан байх
2. Хэрэв суралцагч идэвхгүй төлөвтэй бол идэвхтэй болгох
3. Хэрэв суралцагч батлагдаагүй, цуцлагдсан, хүлээгдэж байгаа бол батлагдсан төлөвт оруулах

I. Суралцагчийн дэвшилтийн бүртгэл хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **Дэвшилт** үйл ажиллагааг сонгоно.
2. Дэвшилт хийх бүлгийг сонгоно.
3. Дэвшилт хийх хүүхдийг сонгож, дэвшилтийн бүртгэл товч дарна.
4. Хэрэв буруу суралцагчийг бүртгэсэн бол тухайн суралцагчийн арын **бүртгэлээс хасах (Х)** товч дарна.

Суралцагчийг дэвшилтийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Дэвшилт**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

Дэвшилт цонхны зүүн хэсэгт байрлах талбараас дэвшилт хийх бүлгийн мэдээллийг сонгоод баруун дээд хэсэгт байрлах **дэвшилтийн бүртгэл** үйлдлийг дарахад дэвшилтийн бүртгэлийн дараах цонх нээгдэнэ.

Дэвшилтийн бүртгэл цонхонд тухайн бүлгийн нийт суралцагчийн нэрсийн жагсаалт гарч ирэх бөгөөд дэвшилтийн бүртгэл хийх суралцагчийн урд талын дөрвөлжинг чеклээд дэвшигч бүртгэх үйлдлийг дарахад тухайн суралцагч бүртгэгдэж, шийдвэр шалтгаан сонгох талбарууд идэвхжинэ. Дээрх зургаас харна уу.

Суралцагчийн өмнөх хараар хүрээлсэн дөрвөлжинг чекл

3.2. Дэвших үйлдэл хийхэд анхаарах зүйлс

3.2. Дэвших үйлдэл хийхэд анхаарах зүйлс

1. Шинэ хичээлийн жилд ЕБС-д орох суралцагчдад **дэвших үйлдэл хийхгүй**. **Зөвхөн төгсөх үйлдэл** хийнэ.
2.
3. Дэвших үйлдэл хийхдээ бүлгийн бүх суралцагч жагсаалтанд байгаа эсэхийг нягтлана шалгана уу? Суралцагч **батлагдсан** (батлагдаагүй, цуцлагдсан, хүлээгдэж байгаа бол *батлагдсан* болгох)**, идэвхтэй** (чөлөө авсан, ирэхээ больсон, түр зогсоосон төлөвтэй байгаа бол *идэвхтэй* болгох) төлөвтэй байснаар дэвших үйлдэл хийх жагсаалтанд орж ирнэ.
4.
5. Бүлгийн бүх суралцагчийн дэвшилтийн бүртгэлийг хийж бүртгүүлсэн төлөвт оруулах. Ингэхдээ шийдвэр, шалтгааныг заавал сонгож хадгалсан байна.
6.
7. Цэцэрлэгийн бэлтгэл ангиас бусад ангид дэвших /давтан суралцуулах үйлдэл хийх боломжтой тул суралцагч нэг бүрт энэхүү үйлдлийг хийж баталгаажуулна.
8.
9. **Дэвшүүлэх** үйлдлийг суралцагч нэг бүрээр хийнэ. Бүх суралцагчдад **шийдвэр** (дэвшүүлэх, давтан суралцуулах) гарч **батлагдсанаар** шинэ хичээлийн жилд тухайн суралцагч **дэвших** эсвэл **тухайн ангидаа давтан суралцах** (тухайн ангидаа үлдэх) боломжтой болно.
10.
11. Дэвшилтийн бүртгэлийг хийж хадгалж, баталгаажуулснаар дэвшүүлэх үйлдэл дуусна. Дараах дарааллаар хийнэ.
    1. Дэвшүүлэх анги бүлгийг сонгож **дэвшилтийн бүртгэл** товчийг дарна.
    2. Дэвшүүлэх үйлдэл хийх суралцагчийн нэрийн өмнөх дөрвөлжинг чеклэж **дэвшигч бүртгэх** товчийг дарна.
        1. Хэрэв дэвшүүлэх бүртгэлийг буцаах бол тухайн суралцагчийн нэрийн ар дахь **X** тэмдэглэгээр дарж бүртгэлийг буцаана.
    3. Суралцагч бүрийн тохирох шийдвэр (Дэвшүүлэх/давтан суралцуулах) шалтгаан болон бусад мэдээллийг сонгож хадгална.
    4. Багш бүлгийн суралцагчийн дэвшилтийн бүртгэлийг хийж дуусаад эрхлэгчид мэдэгдэнэ. Эрхлэгч (арга зүйч) эрхээрээ дэвших үйлдэлд бүртгэгдсэн суралцагчийн мэдээллийг хянаж баталгаажуулна. Бүлгийн бүх суралцагчийн мэдээлэл **Дэвшсэн** эсвэл **Давтан** төлөвт орсноор шинэ хичээлийн жилд суралцагч тохирох ангидаа орох нөхцөл бүрдэнэ. Багш хариуцсан бүлгийн суралцагчийн дэвшилт баталгаажсан (**Дэвшсэн** эсвэл **Давтан)** эсэхээ хянах үүрэгтэй.
    5.
12. Дэвшилтийн бүртгэлийн хугацаа дуусаагүй үед багш мэдээллийг засах шаардлагатай бол эрхлэгч (аргазүйч)-д мэдэгдэж баталгаажуулсан дэвшилтийн мэдээллээ цуцлуулах боломжтой. Эрхлэгч (аргазүйч) эрхээрээ багшийн хүсэлтийн дагуу тухайн бүлгийн тухайн суралцагчийн баталгаажуулсан дэвшилтийг цуцлах үйлдлийг хийнэ.
13.
14. Багш хариуцсан ангийн дэвшилтийн мэдээллийг индикатораар харах боломжтой.
